



Funded by the European Union

TRANSITION
Ministry of Foreign Affairs of the Czech Republic



Баримтын хуудас

Европын холбооны дэмжлэгээр хэрэгжиж буй “Бүгд Залуусын төлөө, Залуус Бүгдийн төлөө” төслийн хүрээнд Иргэний Боловсролын Төвөөс эрхлэн гаргав. Баримтын хуудас нь бие даасан зөвлөхийн судалгаан дээр үндэслэн боловсруулсан бөгөөд Европын Холбооны үзэл баримтлалыг илэрхийлээгүй болно.



Иргэний Боловсролын Төв ТББ



313619



www.facebook.com/cce.mongolia



www.cce.mn



www.twitter.com/cce_mongolia

АГУУЛГА

- Залуучуудын хэрэгцээ шаардлагын судалгаа
- Залуучуудыг дэмжих төрийн бодлого, хөтөлбөр
- Монгол залуучуудын хөгжлийн индекс
- Залуучуудын улс төр, иргэний оролцооны байдал
- Залуучуудын оролцох боломж
- Залуучуудын оролцооны сайн туршлага




Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1-р хороо,
Авто Замчдын гудамж, Хасвуу Плаза, 1-р давхар

Улаанбаатар хот, 2020 он


Залуучуудад тулгамдаж буй асуудлууд болон тэдний сурч боловсрох хэрэгцээ

Доорх мэдээллийг Иргэний Боловсролын Төв ТББ-ын захиалгаар “Эм Эм Си Жи” ХХК-ны гүйцэтгэсэн “Залуучууд, залуучуудын байгууллагын оролцоо, чадавх, хөгжлийг дэмжих сургалтын хэрэгцээг тодорхойлох” судалгаанаас бэлтгэв. Уг судалгаанд Улаанбаатар хот, Дорноговь, Сэлэнгэ, Хэнтий, Баянхонгор аймгийн нийт 480 залуучууд болон залуучуудын ТББ-ууд хамрагдсан байна.

Залуучуудад хамгийн их тулгамдаж буй асуудал нь ажилгүйдэл байна



Залуучуудад зөвлөгөө өгөх үйлчилгээ хамгийн хангалтгүй байна




Залуучуудад зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээ хамгийн дутагдалтай байдаг ба Хэнтий аймагт хамгийн өндөр хувьтай байсан бол Улаанбаатарт амьдрах ухааны боловсрол олгох, сургалт хамгийн дутагдалтай байдаг аж.

Залуучууд ямар үйл ажиллагаанд идэвхтэй оролцох сонирхолтой байна бэ?




Залуучуудад хамгийн их хэрэгцээтэй байгаа ур чадварууд

олон хариулттай асуулт, n=495




Залуучуудын хөгжлийг төр, засгийн газраас дэмжих ёстой

Залуучуудыг, залуучуудын идэвхи оролцоо, хөгжлийг төр, засгийн газрын зүгээс дэмжих ёстой гэж судалгаанд оролцогчдын 10 хүн тутмын 9 нь үзэж байна.



Залуучуудын оролцооны түвшин хангалтгүй байна


Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль"-ийн 4.1.3 дах заалтын дагуу залуучуудын улс төр, эдийн засаг, нийгмийн хөгжил, шийдвэр гаргах түвшинд үзэл бодлоо илэрхийлэх, оролцох үйл явцыг “Залуучуудын оролцоо” гэж тодорхойлно.



64%

Судалгаанд оролцсон залуучуудын 64% нь ямар нэгэн байгууллага, холбоо, клубт гишүүнчлэлгүй байна.

Залуучуудын оролцохгүй байгаа шалтгаан юу вэ?




Залуучуудын иргэний нийгмийн байгууллагуудын чадавх, тэдэнд тулгардаг бэрхшээлүүд*


*Доорх мэдээллийг “Бүгд залуусын төлөө, Залуус бүгдийн төлөө” төслийн суурь судалгаанаас бэлтгэв. Уг судалгаанд Улаанбаатар хот, Хэнтий, Сэлэнгэ, Дорноговь, Баянхонгор аймгийн залуучуудын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн төлөөлөл болсон нийт 124 оролцогч хамрагджээ.

Залуучуудын иргэний нийгмийн байгууллагуудын явуулж буй үйл ажиллагааны чиглэлүүд

Хамгийн түгээмэл үйл ажиллагааны чиглэлүүд:




Хамгийн бага үйл ажиллагаа явуулдаг чиглэлүүд:




Залуучуудын иргэний нийгмийн байгууллагуудын хүний нөөц


Удирдах албан тушаалтны тоо



Үндсэн ажилчдын тоо



Судалгаанд хамрагдсан төрийн бус байгууллагуудын



Үйл ажиллагаа явуулахад хамгийн их тулгардаг нийтлэг бэрхшээлүүд




Иргэний нийгмийн байгууллагуудын ажилчдын ур чадвар*

*Судалгаанд оролцогчид өөрсдийн ажилчдын ур чадварыг 0-5 хүртэлх оноогоор үнэлсэн.




Залуучуудын идэвхтэй, утга учиртай, бодит оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна

Залуучуудын иргэний оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр ямар үйл ажиллагаа явуулж байсан бэ?



Залуучуудын ТББ-уудад сайн дурын ажилтны цогц хөтөлбөр, чанартай сургалтын агуулга шаардлагатай байна



Залуучуудад зориулсан төрийн бодлого, хөтөлбөр, хөрөнгө оруулалт

Залуучуудын хөгжлийг дэмжсэн бодитой хөрөнгө оруулалт дутагдаж байна

“Хөтөлбөр байгаад байгаа хэдий ч төсөв хөрөнгийн асуудлыг нь шийддэггүй. Төсөвгүй төлөвлөгөө гэдэг бол хэрэгждэггүй. Нийгмийн салбарт чиглэсэн багц санхүүжилтээс тодорхой хэмжээг нь залуучуудын төсөл хөтөлбөрт манай аймаг зарцуулдаг. Хүүхэд хамгааллын сангаас бараг 20 сая төгрөгийг залуучууд руу чиглэж санхүүжүүлдэг. Хүүхэд хамгааллын сангийн санхүүжилтийн 18%-ийг залуучууд руу, 18%-ийг нь гэр бүл рүү үлдсэнийг нь хүүхэд рүү гээд хуваарилж ажиллаж байгаа”.

Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар

“Залуучуудад зориулсан хөрөнгө оруулалт бол хангалтгүй байдаг. Үндэсний байгууллага нь өөрөө залуучуудын хөгжлийг дэмжиж ажиллахад өөрийн гэсэн төсөв байхгүй байна. Залуучуудын хөгжлийг дэмжих хуульд залуучуудын хөгжлийг дэмжих сантай байна гэж заасан. Сангаараа дамжуулан үйл ажиллагаа явуулна гэсэн боловч сан нь одоо хүртэл байгуулагдаагүй байна”.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар, Залуучуудын хөгжлийн газар




Залуучуудын 33% нь буюу гурван залуу тутмын нэг нь өөрийн амьдарч буй орон нутаг, дүүрэгт төрийн зүгээс залуучуудын хөгжилд зориулсан томоохон ажил, хөрөнгө оруулалт огт хийгээгүй гэж үзэж байна.

33%

Эх сурвалж: “Залуучууд, залуучуудын байгууллагын оролцоо, чадавх, хөгжлийг дэмжих сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгаа”

Танай орон нутаг, дүүрэгт залуучуудын хөгжилд чиглэсэн төрийн хамгийн том ажил, хөрөнгө оруулалт юу байсан вэ?




Тус судалгаагаар залуучуудад тулгамдаж буй хамгийн том асуудал нь ажилгүйдэл байв. Залуучуудад зориулсан төрийн томоохон ажил, хөрөнгө оруулалтыг нэрлэнэ үү гэж асуухад залуучууд ихэвчлэн спортын ордон, заал, цогцолбор, цэцэрлэг, саад, тоглоомын талбай гэх мэт барилга барьсан жишээг дурдаж байна. Харин залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн төрийн аливаа ажил, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын талаар залуучууд маш бага мэдээлэлтэй байна.

“Залуучуудын хөгжлийг дэмжих хууль, Залуучуудын хөгжлийн төвийн талаар анх удаа сонсож байна. Залуучуудад хүргэх нөлөөллийн ажлыг бага хийсэн байж магадгүй. Зорилтот бүлэгтээ нийгмийн хүрээнд олон ажлуудыг хийх ёстой. Ийм ажлуудыг хангалттай хийгээгүй байна гэж дүгнэж болохоор байна”.

15-17 НАСНЫ БҮЛГИЙН ФОКУС БҮЛГИЙН ЯРИЛЦЛАГААС

Залуучуудад чиглэсэн төрийн бодлогын баримт бичгүүдтэй уншиж танилцсан залуучуудын хувь



- Аймаг, нийслэлийн гэхээхг-ын төлөвлөгөө, тайлан, 2016-2020
- Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр, 2019
- Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, 2017
- МУ-д үйл ажиллагаа эрхэлдэг залуучуудын төрийн байгууллагуудыг чадавхжуулах төлөвлөгөө, 2014
- “Нийслэлийн залуучууд” дэд хөтөлбөр, 2017

Монгол залуучуудын улс төрийн оролцоо дэлхийн дунджаас бага үнэлэгдэж байна

Залуучуудын хөгжлийн индекс

“The Commonwealth of Nations” байгууллагаас эрхлэн гаргасан 2016 оны Залуучуудын хөгжлийн индекс нь эрүүл мэнд, боловсрол, ажил эрхлэлт, нийгмийн оролцоо, улс төрийн оролцоо гэсэн 5 шалгуураар дэлхийн 183 улсын залуусын хөгжлийн төвшинд үнэлгээ өгдөг. Дээрх үндсэн шалгууруудад 0-1 оноо өгч тухайн улсын үнэлдэг бөгөөд 0 оноо нь хамгийн муу үнэлгээг илэрхийлэх бол 1 оноо нь авч болох хамгийн сайн үнэлгээ юм.

Дэлхийн дундаж **0.616**


Эрүүл мэнд **0.636**

Улс төрийн оролцоо **0.573**

Боловсрол **0.714**

Нийгмийн оролцоо **0.509**

Ажил эрхлэлт **0.567**



Залуучуудын хөгжлийн индексээр Герман, Дани, Австрали улсууд дэлхийд тэргүүлж Зааны Ясан Эрэг, Чад, Төв Африкийн БНУ зэрэг улс сүүлд оржээ. Харин Монгол Улс 183 орноос 71-р байранд орсон ба залуусын эрүүл мэнд, улс төрийн оролцоогоор дэлхийн дунджаас доогуур оноо авсан байна.

Залуучуудын хөгжил, оролцоог дэмжсэн олон улсын сайн жишээ

Улс төрд залуусын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор нийт 25 улс ямар нэгэн төрлийн залуучуудын квотыг ашиглаж байна.

Руанда, Марокко, Кени, Уганда улсын парламентын суудлын тодорхой хувийг заавал 35-40 насны залуус бүрдүүлэхээр хуульчилсан байдаг. Жишээлбэл Руанда улсын парламентын суудлын хамгийн багадаа 7.7% нь 35 хүртэлх насны бүлэг байх ёстой байдаг нь дэлхийд хамгийн өндөр залуусын квот юм.

- 1 Филиппин, Тунис, Киргиз зэрэг улсуудад намаас сонгуульд нэр дэвшигчдийн тодорхой хувийг заавал залуус бүрдүүлэх ёстой гэж хуульчилсан байдаг.
- 2 Никарагуа, Швед, Литва зэрэг улсуудад улс төрийн намууд сайн дураараа нэр дэвшигчдийнхээ тодорхой хувийг заавал залуусаар бүрдүүлдэг байна.



Залуучуудын хөгжлийн индексийн боловсролын үзүүлэлтээр дэлхийд тэргүүлж буй Нидерланд улсын залуучуудын хөгжлийг дэмжих бодлого нь дараах шинж чанартай байна:

- 1 Залуучуудыг суурь боловсролтой болгох, сургуулийн дипломтой төгсгөх, улмаар өөрийн ур чадварт тохирсон ажилтай болгоход өндөр ач холбогдол өгдөг.
- 2 ЗГ-аас залуусын боловсрол, ажил эрхлэлтийг дэмжсэн тогтвортой бодлого хэрэгжүүлж, бизнесийн салбарын ААН-үүдтэй хамтарч залуусын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгай хуулийг 2014 онд баталсан.
- 3 Залууст дунд сургуулиас эхлэн бизнес эрхлэх тухай хичээл заахын сацуу “хийж байж сурья” нэртэй дадлагын хөтөлбөрийг хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлдэг.
- 4 Төр нь ерөнхий бодлого, алсын хараа, гол стратегийн зорилтуудыг нийгмийн олон төрлийн оролцогч талуудтай хамтарч баталдаг. Бодлогын хэрэгжилтийг орон нутгийн засаг захиргаа голчлон хариуцдаг.

Парламентад суудалтай улс төрийн намуудын 2020 оны УИХ-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрөөс онцлох нь



**МОНГОЛ
АРДЫН НАМ**

Монгол Ардын Нам

- 1 Гарааны бизнес эрхлэгч оюутан, залууст бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 2 **★ Хөгжлийн тэргүүлэх чиглэлээр суралцаж байгаа болон сурлагын амжилтаар тэргүүлэгч оюутнуудад 100 хувь хүртэл сургалтын төлбөрийн тэтгэлэг олгох “Үндэсний тэтгэлэгт хөтөлбөр” хэрэгжүүлнэ.**
- 3 **★ Гадаадад их, дээд сургууль төгссөн залуучуудаа эх нутагтаа эргэн ирж ажиллаж хөдөлмөрлөх, бизнес эрхлэхэд нь дэмжлэг үзүүлж, урамшуулах тогтолцоог бүрдүүлсэн цахим мэдээллийн систем, хөдөлмөрийн бирж бий болгоно.**

- 4 Залуучууд, залуу гэр бүлийг орлогод нь нийцсэн, уян хатан төлбөрийн нөхцөлтэй орон сууц худалдан авахад дэмжлэг үзүүлнэ.
- 5 Залуучуудын хөгжлийг дэмжих сан байгуулна.
- 6 Залуу гэр бүлийн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүй, хөгжлийн хэрэгцээг дэмжсэн “Залуу гэр бүл” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 7 Гэр бүл, хүүхэд, оюутан залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх орчин бий болгоход зориулсан төвүүд байгуулна.
- 8 Хүүхэд, оюутан, залуучууд, өсвөр үеийнхнийг гадны сөрөг нөлөө, бусдын дарамт, гэмт хэрэгт өртөх, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэхээс сэргийлэх, цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах хөтөлбөр хэрэгжүүлнэ.

★ Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан



Ардчилсан Нам

- 1 Хот болон хөдөө орон нутагт, төр болон хувийн өмчит сургуульд суралцагсдын дундаж онооны зөрүү 50-182 байгааг үе шаттай бууруулах “Боловсролын чанарын ялгааг арилгах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.
- 2 Бүх оюутныг сургалтын зээл авах тэгш боломжоор хангана
- 3 Гадаад орны их, дээд сургуульд 10,000 оюутныг /ялангуяа дэлхийн шилдэг 100 их дээд сургуульд/ суралцах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллана.
- 4 Гадаадад суралцаж, ажиллаж байгаа болон эх орондоо эргэн ирж буй залуучуудад зориулж “XXI зууны диаспора” хөтөлбөрийг олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

- 5 Амжилттай хэрэгжиж буй “Мянган инженер” хөтөлбөрийг “Түмэн инженер” хөтөлбөр болгон үргэлжлүүлнэ.
- 6 Англи хэлийг боловсролын хоёр дахь хэлний түвшинд хүргэж, бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт оруулна.
- 7 Залуу гэр бүл, гэр хорооллын айл өрхүүд, бусад зорилтот бүлгийн 100 мянган өрхийг түрээсийн орон сууцаар хангах ажлыг эхлүүлнэ.
- 8 Мэргэжилтэй ажиллах хүчин, дээд боловсрол олгох их, дээд, дунд мэргэжлийн сургуулиудын сургалтын хөтөлбөрийг өсөн нэмэгдэж буй шинэ ажлын байрны хэрэгцээ шаардлагатай нийцүүлэх замаар шинэ төгсөгч оюутан бүрийг үе шаттайгаар хөдөлмөрийн зах дээл дээр ажлын байр бий болгож, хангана.



“Зөв Хүн Электорат” эвсэл

(Хөдөлмөрийн Үндэсний Нам, Монголын Социал Демократ Нам, Зүй Ёс Нам)

- 1 Бүх шатны боловсрол олгоход технологийн болон гадаад хэлний мэдлэгийг түлхүү анхаарч, танхимын болон онлайн сургалтыг эрчимтэй нэвтрүүлнэ.
- 2 Бүрэн дунд боловсролыг мэргэжлийн сургалттай хослуулсан аж үйлдвэр болон хөдөө аж ахуйн гүнзгийрүүлсэн сургалтыг төрөөс дэмжинэ.
- 3 Аймаг, дүүргийн хүүхэд залуучууд, ахмад настнуудад зориулсан сургалт, соёл хөгжлийн төвүүдийг дэмжих арга хэмжээ авна.

- 4 Залуу гэр бүлийн орлогод нийцсэн орон сууцжуулах хөтөлбөр хэрэгжүүлэх бодлого баримтална.



“Та Бидний Эвсэл”

(Монгол Ардын Хувьсгалт Нам, Иргэний Зориг Ногоон Нам, Монголын Уламжлалын Нэгдсэн Нам)

- 1 Ерөнхий боловсролын сургууль, МСҮТ, коллеж, их, дээд сургуулиудын үндсэн хөтөлбөрүүдийг онлайн болгож, их, дээд сургуулиудад диплом олгох онлайн сургалт явуулах эрхийг албан ёсоор зөвшөөрөх хууль эрх зүйн орчныг бий болгоно.
- 2 Гарааны бизнесийг дэмжих “Старт ап” хөтөлбөрийг хэрэгжүүлж, бизнес эрхлэгч залуучуудад зориулсан “Дундын оффис” байгуулан ажиллуулах буюу тодорхой хугацаанд түрээс төлөлгүйгээр өөрийн төсөл, хөтөлбөр, шинэ санааг боловсруулах ажил хийх нөхцөлийг бүрдүүлнэ.


- 3 Залуучуудын бизнес санаачлалыг дэмжих “Старт ап” банк байгуулж ажиллуулна. Жил бүр наад зах нь 1000 гарааны бизнесийг дэмжих бодлого боловсруулна.

2020 оны УИХ-ын сонгуулийн ирц

- 75%-аас дээш
- 70%-75% хооронд
- 70%-аас доош



2020 оны УИХ-ын сонгуулийн ирц




2020 оны УИХ-ын сонгуульд хөдөө орон нутгийн 18-25 насны залуусын 60% нь саналаа өгсөн бол нийслэлийн залуусын сонгуулийн ирц 67% байжээ. Булган аймгийн залуусын ирц 51% буюу бусад аймгуудаас хамгийн бага байв. Харин Баян-Өлгий аймаг болон УБ хотын Хан-Уул дүүргийн залуусын ирц хамгийн өндөр буюу ойролцоогоор 74% байв.

! Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулинд 15-34 насны залуучуудад тооцдог боловч Сонгуулийн ерөнхий хороо, Статистикийн үндэсний газар, Улсын бүртгэл зэрэг төрийн байгууллагууд энэ ангиллаар тоо баримт, мэдээллийг гаргадаггүй байна.

- 19 Тойрог
- 69.2% Сонгуулийн ирц (бүх насны бүлэг)
- 55.1% Сонгуулийн ирц (18-25 насны бүлэг)
- 55.1% Сонгуулийн ирц (26-40 насны бүлэг)


УИХ-ын сонгуульд залуучуудын оролцоо

Хүн амын нас, хүйсийн суварга, 2019




Монгол улсын хүн амын талаас илүү хувийг 30-с доош насны залуус бүрдүүлдэг. Гэвч залуусын сонгуулийн ирц бусад насны бүлгүүдээс хамгийн бага байдаг. Залуусын сонгуулийн идэвх оролцоо муу байгаа нь тэдний хүсэл эрмэлзэл, дуу хоолой төрийн бодлогод тусгагдахгүй орхигдох эрсдэлтэй.

УИХ-ын сонгуульд залуучуудын идэвх, оролцоо ямар байсан вэ?



Ардчилсан хувьсгалын дараа төрсөн шинэ, залуу сонгогчдын улс төрийн оролцоо хангалтгүй байсаар иржээ. Тухайлбал, 18-25 насны залуу сонгогчдын ердөө 38% нь 2012 оны сонгуульд, 50.8% нь 2016 оны сонгуульд тус тус оролцож байв. Харин 2020 оны сонгуульд залуусын оролцоо өмнөх жилүүдийнхээс нэмэгдэж тэдний сонгуулийн ирц 62.5% болсон байна.


Залуучууд УИХ-ын сонгуульд яагаад оролцдог вэ?¹



Ихэнх залуус саналаа өгөх нь иргэний үүрэг учраас сонгуульд оролцдог байна. Залуус сонгуульд оролцоходоо нам, нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрт дүн шинжилгээ хийсний үндсэн дээр саналаа өгдөг байвал тэдний оролцоо нь илүү утга учиртай болох боломжтой.

Залуучууд УИХ-ын сонгуулиар хэнд санал өгөхөө хэрхэн шийддэг вэ?

2020 оны УИХ-ын сонгуульд санал өгөхдөө юунд илүү ач холбогдол өгөх вэ?¹




Ихэнх залуус санал өгөхдөө нэр дэвшигчдийн өмнө нь хийж бүтээсэн зүйлс, ажил хөдөлмөрийн амжилт болон боловсролын төвшинд их ач холбогдол өгдөг байна. Харин ойролцоогоор 5 залуусын 2 нь намын мөрийн хөтөлбөрт ач холбогдол өгдөг байна.


Эх сурвалж: 1. Залуу Сонгогчдын Судалгаа, Зориг сан, 2020 N=600

2020 оны ИТХ-ын сонгуулийн ирц

■ 65%-аас дээш
■ 55%-65% хооронд
■ 55%-аас доош



2020 оны ИТХ-ын сонгуулийн ирц (албан бус тооцоолол)




- 18-25 насны залуусын ойролцоогоор 37.4% нь ИТХ-ын сонгуульд саналаа өгсөн бөгөөд энэ нь өмнөх удаагийн орон нутгийн сонгуулийн ирцээс 4.8%-аар өссөн байна.
- Насны бүлэг нэмэгдэх тусам иргэдийн ИТХ-ын сонгуулийн ирц нэмэгдэж байгаа бөгөөд 2020 оны ИТХ-ын сонгуульд 56 ба түүнээс ахмад насны иргэд хамгийн өндөр ирцтэй оролцжээ.
- Баян-Өлгий аймгийн залуусын ирц ойролцоогоор 58% байсан нь бусад аймгаас хамгийн өндөр нь байв.
- Дархан-Уул аймгийн залуусын сонгуулийн ирц хамгийн бага буюу ердөө 19% байжээ.

■ 69.2% → Сонгуулийн ирц (бүх насны бүлэг)
■ 55.1% → Сонгуулийн ирц (18-25 насны бүлэг)
■ 55.1% → Сонгуулийн ирц (26-40 насны бүлэг)

ИТХ-ын сонгуульд залуучуудын оролцоо

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн ирц



Орон нутгийн ИТХ-ын сонгуульд иргэдийн оролцоо бусад сонгуулаас хамгийн бага байдаг. Сүүлийн 7 удаагийн ИТХ-ын сонгуулийн ирц нь тухайн жилийн УИХ-ын сонгуулийн ирцээс дунджаар 16%-аар бага байжээ.

Орон нутгийн сонгуульд залуучуудын оролцоо яагаад сул байна вэ?

1

Сонгуулийг **10 сард** буюу их дээд сургуулиудын хичээл амраагүй байх үед зохион байгуулдаг учраас хөдөө, орон нутгаас УБ хотод түр оршин сууж буй **80,000 гаруй оюутан** залуучууд санал өгч чадаагүй байх магадлалтай.

2

Сонгуулийн **ирцийн босго байхгүй болгосон** нь залуучуудын сонгуульд оролцох сэдэлд сөргөөр нөлөөлсөн.

3


ИТХ-ын сонгуулийн ач холбогдлын талаар **залуучууд хангалттай мэдээлэлгүй** байдаг учраас сонгуулийг үл ойшоодог.

4

Сонгуулийн **сурталчилгааны хугацаа ердөө 15 өдөр** байдаг учраас залуу нэр дэвшигчид иргэд сонгогчдод өөрийгөө таниулж чаддаггүй. Энэ нь залуу сонгогчдын ирцэд сөргөөр нөлөөлдөг.

Яагаад ИТХ-ын сонгуульд саналаа өгөөгүй вэ?²

2020 оны 11 сард 1000 гаруй иргэдийн дунд судлаач С.Болдсайханы хийсэн судалгаанд оролцсон 18-25 насны залуусын сонгуульд оролцоогүй хамгийн түгээмэл шалтгаан нь хаягийн зөрчил (48.2%) байв. Харин бусад насны бүлэгтэй харьцуулахад залуусын маш бага хувь нь “сонгуулийг сонирхоогүй, ач холбогдол өгөөгүй,” “сонгох нэр дэвшигч байгаагүй,” эсвэл “сонгуулийг шударга бус явагдана гэж бодсон” гэх мэт сөрөг хариулт өгсөн байна.




Эх сурвалж: 2. Сонгуулийн дараах судалгаа, 2020 С.Болдсайхан, нээлттэй асуулт, N-341

2020 оны ИТХ-ын сонгуулиар сонгогдсон төлөөлөгчдын тоо, хүйсээр




Улс төрд залуучууд, эмэгтэйчүүдийн төлөөлөл бага байна

УИХ-ын гишүүд, насны бүлгээр




Дэлхий дахины бүх парламентын гишүүд, насны бүлгээр



30 хүртэлх насны парламентын гишүүдийн эзлэх хувиараа дараах улсууд дэлхийд тэргүүлж байна. Монгол улсын УИХ-ын гишүүдийн 2.63% нь 30 хүртэлх насны залуус байсан бөгөөд уг судалгаанд багтсан 150 улсаас 45-р байранд оржээ.

Эх сурвалж: "Youth Participation in National Parliament, 2018."




2020 оны байдлаар УИХ-д 30 хүртэлх насны нэг ч гишүүн байхгүй байна. Харин 40 хүртэлх насны 7 гишүүн байгаа нь УИХ-ын нийт гишүүдийн 9.2% юм.

Та мэдэх үү?


Сонгуулийн пропорционал буюу хувь тэнцүүлэх тогтолцоо нь улс төр дэх залуусын төлөөллийг нэмэгдүүлдэг давуу талтай.

Улс төрд залуучуудын төлөөлөл яагаад хангалтгүй байна вэ?



Эх сурвалж: Монгол улс дахь санал бодлын судалгаа. БНОУХ, 2020.

УИХ-ын гишүүд, хүйсээр



Дэлхий дахинд 2019 оны байдлаар парламентын нийт гишүүдийн 24.6% нь эмэгтэйчүүд байгаа бол Монгол улсын УИХ-ын гишүүдийн 17.3% нь эмэгтэйчүүд байна. Улмаар манай улс эмэгтэйчүүдийн парламентад эзлэх хувиар дэлхийн 188 улсаас 125-д орж байна. Түүнчлэн манай улсын ардчилсан түүхэнд нэг ч эмэгтэй хүн аймаг, нийслэлийн засаг даргаар ажиллаж байгаагүй юм.



*2018 ОНЫ БАЙДЛААР

Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс онцлох нь

2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт:

- 1 Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад сувилагч мэргэжлээр суралцагчдад сургалтын амжилттай нь уялдуулан 100 хүртэл хувийн тэтгэлэг олгоно.
- 2 ★ Хөгжлийн тэргүүлэх чиглэлээр суралцаж байгаа болон сургалт, судалгааны ажлын амжилтаар тэргүүлэгч оюутнуудад 100 хувь хүртэл сургалтын төлбөрийн тэтгэлэг олгох “Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэгт хөтөлбөр” хэрэгжүүлнэ.
- 3 Гэр бүл, хүүхэд залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг дээдэлсэн, нийгмийн бүх бүлгийн оролцоог хангасан хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ.
- 4 “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх арга хэмжээ”-г хэрэгжүүлж, “Оюутан-цэрэг” сургалтад суралцагчдын тоог нэмэгдүүлнэ.
- 5 ★ Гадаадад сурч, хөдөлмөрлөж байгаа монгол иргэдийг дэмжих, эх орондоо эргэн ирж ажиллаж хөдөлмөрлөхөд дэмжлэг үзүүлэх хөдөлмөрийн бирж бий болгоно.

★ МАН-ын 2020 оны сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан амлалтууд



“Залуучуудын хөгжлийг дэмжих тухай” хуулиас онцлох нь

2017 онд батлагдсан энэхүү хууль нь 15-34 насны залуучуудын хөгжил, оролцоог дэмжихэд үйлчлэх аж.

Залуучуудын хөгжлийг дэмжих үйл ажиллагааг дараах чиглэлээр зохион байгуулах аж.

1. Залуучуудын хувь хүний хөгжлийг дэмжих тухай онцлох заалтууд:

- Бүх төрлийн сургалтын хөтөлбөрт хувь хүний хөгжлийг дэмжих, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх хичээлийн агуулгыг тусгана
- Түүх, соёлоо мэддэг, эх оронч үзэлтэй, бие дааж амьдрах чадвартай, хариуцлагатай иргэн болж төлөвшихөд чиглэсэн амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх хөтөлбөрийн дагуу цэргийн мэргэжил олгох сургалтад 18-27 насны залуучуудыг хамруулна



2. Залуучуудын боловсрол, соёл, урлаг, спорт, шинжлэх ухааны хөгжлийг дэмжих тухай онцлох заалтууд:

- Үндэстний цөөнх, шилжин суурьшигч, зорилтот бүлгийн залуучуудын боловсролын хэрэгцээнд суурилсан сургалтыг насан туршийн боловсролын хөтөлбөрийн дагуу эзэмшүүлнэ
- Номын сангийн үйлчилгээг залуучуудад хүртээмжтэй болгох арга хэмжээ авч, цахим номын сан хөтөлбөрийг хэрэгжүүлнэ
- Залуучуудын нийгэм, улс төрийн оролцоо, нас, сэтгэхүй, бие бялдар, түүх соёлын хөгжлийг судлахад чиглэсэн залуучууд судлалыг хөгжүүлнэ.
- Шинжлэх ухаан, өндөр технологи, инноваци, шинжилгээ, судалгааны чиглэлээр үндэсний тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлнэ.

3. Залуучуудын аюулгүй амьдрах, хөгжих орчныг бүрдүүлэх талаарх онцлох заалтууд:

- Орлоготой нь нийцсэн, уян хатан төлбөрийн нөхцөлөөр орон сууц худалдаж авах, түрээслэх, зорилтот бүлгийн залуучууд, залуу гэр бүлийг орон сууцжуулах хөтөлбөрийг залуучуудын болон барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран хэрэгжүүлнэ.
- Залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэсэн, соёл, урлаг, биеийн тамир, спортын цогцолбор, хөгжлийн

төв, цэцэрлэгт хүрээлэн, дэд бүтцийг шинээр барьж байгуулах, өргөтгөх төсөл, арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлнэ

4. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай онцлох заалтууд:

- Оюутан, залуучуудыг ажилд зуучилсан хөдөлмөрийн биржийг дэмжинэ
- Залуучуудыг хувиараа болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр хөдөлмөр эрхлэхийг дэмжинэ
- Гадаад улсын тэргүүн туршлага, өндөр технологи, шинэ санааг үндэсний технологи болгон нутагшуулах, гарааны компани эрхлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.
- Малчин залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ
- Гадаад улсад өндөр технологи, нарийн мэргэжил, ур чадвар эзэмшсэн залуучуудыг эх орондоо ажиллахыг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлнэ
- Мэргэжлийн ур чадвараа сайжруулах, шинэ мэргэжил эзэмших сургалтад ажилгүй залуучуудыг хамруулна
- Орон нутгийн захиалгат ажлын байранд ажиллахаар очсон залуучуудыг дэмжинэ
- Ажил олоход хүндрэлтэй болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг төгссөн төгсөгчдийг дадлагажуулан байнгын ажлын байраар хангасан ажил олгогчийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас дэмжинэ



5. Залуучуудын эрүүл мэндийг хамгаалах тухай онцлох заалтууд:

- Оюутан, суралцагчийг харьяалал харгалзахгүй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулна.
- Өсвөр үе, залуучуудад ээлтэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх, цахим эрүүл мэндийн үйлчилгээг нэвтрүүлнэ.
- Залуучуудад гэр бүл төлөвлөлт, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг, зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулна.
- Зорилтот бүлгийн залуучуудад чиглэсэн биеийн тамир, спорт, сэтгэл зүй, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлнэ.

Төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшинд залуучууд хэрхэн оролцож болох вэ?

Иргэний оролцоо гэж юу вэ?

"Иргэдээс төрийн байгууллага, ажилтны бодлого, шийдвэр, үйл ажиллагааг дэмжих болон тэдгээрт нөлөөлөхийн төлөө хийж байгаа аливаа үйл ажиллагаа, үйл явцыг иргэний оролцоо гэж нэрлэж болно."

- Иргэдийн оролцооны эрх зүйн орчин ба үнэлгээ, судалгааны тайлан. Улс төрийн боловсролын академи. 2013 он

Иргэний оролцоо нь дараах нийтлэг шинж агуулдаг

- 1 Иргэний оролцооны зорилго нь гаргах гэж буй, эсхүл нэгэнт гаргасан шийдвэрт нөлөөлөхөд оршино.
- 2 Иргэний оролцоо бол иргэнд зөвхөн мэдээлэл өгөх бус харин шийдвэр гаргагч иргэдийн харилцан хамтын ажиллагаа байдаг.
- 3 Иргэдийг оролцуулна гэдэг нь гэнэтийн, тохиолдлын шинжтэй үйл явдал бус харин зохион байгуулалттай, тогтолцоо бүхий үйл ажиллагаа байх ёстой.
- 4 Иргэний оролцоо нь захиргааны шийдвэр, үйл ажиллагаанд илүү хамааралтай буюу гүйцэтгэх эрх мэдлийн салбарт түгээмэл тохиолдоно.

Эх сурвалж: "Иргэний Оролцоо Гарын Авлага. Иргэний Нээлттэй Боловсрол НҮТББ. 2018 он

Иргэний оролцооны зохицуулалттай хуулийн тоо сүүлийн жилүүдэд нэмэгдэж байна

1992 оноос 2017 оны 7 дугаар сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд иргэний оролцооны зохицуулалт, заалттай нийт 109 хууль батлагдсан байна. Дээрх хуульд иргэний оролцооны нийт 308 зохицуулалт байна.

Иргэний оролцооны зохицуулалттай хуулийн тоо



Иргэний оролцооны зохицуулалттай хуулийн заалтуудын 67% нь ямар нэгэн байдлаар хэрэгжиж байна



Үндсэн хуульд заасан иргэний оролцоо

"Засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ."

- Монгол Улсын Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг



Төлөөллөөр Дамжуулж Оролцох

Ерөнхийлөгч, УИХ, орон нутгийн ИТХ-ын сонгуульд саналаа өгч өөрийн төлөөллийг сонгох эрхтэй.



Шууд оролцоо

Багийн, хорооны иргэдийн нийтийн хуралд шууд оролцож шийдвэр гаргах эрхтэй



Бусад хуульд заасан иргэний оролцоо

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-д асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлэх эрхтэй



"Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэн тухайн шатны Хуралд, сум, дүүрэг, баг, хорооны Хурал зохих дээд шатны Хуралд асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлж болно."

- Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24.2.

Зөвлөлдөх санал асуулга болон олон нийтийн нээлттэй санал асуулгад оролцох эрхтэй



"Зөвлөлдөх санал асуулга" гэж нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар төрийн шийдвэр гаргахын өмнө болон түүнийг хэрэгжүүлж, сахин мөрдөж байгаа байдлын талаар тохиолдлын зарчмаар түүвэрлэн сонгосон иргэдээс тусгай бэлтгэсэн асуулгаар санал авах замаар иргэдийг төрийн үйл хэрэгт оролцуулах цогц үйл ажиллагааг хэлдэг.

- Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн 3.1.1.

"Баг, хорооны Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна."

- Төсвийн тухай хуулийн 63.1.

Төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшинд залуучууд хэрхэн оролцож болох вэ?

Төрийн бус байгууллагаар дамжуулж төрийн шийдвэрт нөлөөлөх, саналаа хүргэх эрхтэй



“Хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас гаргах шийдвэрийн төсөл боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд саналыг нь үндэслэн төрийн бус байгууллагыг оролцуулж болно.”

- Төрийн бус байгууллагын тухай хууль 5.

“Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлж, санал авах”

- Хууль тогтоомжийн тухай хууль 8.1.5.

“Хууль тогтоомжийн төсөлд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллагын саналыг авах”

- Хууль тогтоомжийн тухай хууль 8.1.6.

Төрийн байгууллагын дэргэдэх зөвлөл, сан зэрэг иргэдийн төлөөлөл багтсан байгууллагад элсэж төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд хяналт тавих эрхтэй



“Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд олон нийтийн хяналт тавих чиг үүргийг Олон нийтийн хяналтын зөвлөл гүйцэтгэнэ.”

- Төрийн албаны тухай хууль 56.1.

Нийтийн сонголд оролцож, үзэл бодол, байр сууриа илэрхийлэх, санал гомдолоо уламжлах эрхтэй



“Нийтийн сонголд” /цаашид “сонголд” гэх/ гэж хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актыг тогтоох, төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, түүнчлэн хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актыг хэрэгжилтийг үнэлэх, нийтийн эрх ашгийг хөндсөн асуудлаар шийдвэр гаргахын өмнө төрийн байгууллага, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн шинжээчээс санал сонсох, мэдээлэл авах үйл ажиллагааг хэлнэ.

- Төрийн бус байгууллагын тухай хууль 5.

Таны эрх ашгийг хөндсөн шийдвэр гаргасан захиргааны байгууллагын шийдвэр гаргах ажиллагаанд оролцох эрхтэй



“Хуульд заасан эрх зүйн чадамжтай иргэн, хуулийн этгээд болон хуулиар эрх олгогдсон этгээд захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд оролцох эрхтэй.”

- Захиргааны ерөнхий хууль 14.1.

“Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны талаар хуульд заасан журмын дагуу мэдээлэл авах, холбогдох баримт бичгийг хуулбарлан авах эрхтэй”

- Захиргааны ерөнхий хууль 15.1.1.

Нийтийн ашиг сонирхлын төлөө эрх бүхий байгууллагуудаас үүргээ гүйцэтгэхийг шаардах, хууль зөрчсөн албан тушаалтнуудыг шүүхэд өгөх, нийтийн өмчид учруулсан хохирлыг гаргуулах эрхтэй.



“Захиргааны байгууллагын нийтийн эрх зүйн харилцаанаас үүссэн хууль бус үйлдэл, эс үйлдэхүйгээс өөрт учирсан хохирлыг арилгуулахаар иргэн, хуулийн этгээд шаардах эрхтэй”

- Захиргааны Ерөнхий хууль 100.1.

“Иргэн, хуулийн этгээд өөрт учирсан хохирлыг хохирол учруулсан захиргааны байгууллагаас нэхэмжилж, тухайн захиргааны байгууллагаас гаргуулна.”

- Захиргааны Ерөнхий хууль 101.2.

Шилэн дансны тухай хуулиар төрийн үйл ажиллагаанд дараах байдлаар хяналт тавих эрхтэй:

- 1 Татвар төлөгчдийн мөнгийг ямар зорилгоор, юунд зарцуулж байгааг ямар нэгэн хөндлөнгийн оролцоогүйгээр шууд мэдэх боломжтой.
- 2 Энэ хуулиар төрийн бүх байгууллага төсөв санхүүгийн үйл ажиллагаа, мөн төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авч байгаа бол байгууллагынхаа албан ёсны цахим хаягт дэлгэрэнгүйгээр, иргэдэд ойлгомжтой хэлбэрээр байршуулахыг үүрэг болгосон.
- 3 “Иргэн, хуулийн этгээдийн татвар төлөгчийн эрх ашиг зөрчигдсөн гэж” үзвэл захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргах эрхтэй.

Улс төр дэх залуучуудын төлөөлөл

Залуу нэр дэвшигчдэд тулгардаг нийтлэг бэрхшээл

- 1 Сонгуулийн тойргийн хэмжээ том, сонгогчдын тоо нь их байдаг учраас сонгогч бүрд хүрч ажиллахад маш их цаг хугацаа, хүн хүч, хөрөнгө мөнгө шаардагддаг.
- 2 Улс төрийн намаас залуу нэр дэвшигчдэд санхүүжилт олгодоггүй. Эсрэгээрээ нэр дэвших эрх олж авахын тулд асар их мөнгө, хөрөнгийг намд өгөх шаардлагатай байдаг.



- 3 Сонгуулийн сурталчилгааны хугацаа богинохон байдаг учраас шинэ, залуу, олны танил болж амжаагүй нэр дэвшигчид өөрийгөө хангалттай таниулж амждаггүй.
- 4 Улс төр, сонгуулийн туршлагатай хүний нөөцөөр багаа бүрдүүлж чаддаггүй. Сонгуулийн чухал албан тушаалд ихэвчлэн найз нөхдөө дайчилдаг.
- 5 Тойргийнхоо иргэдийн амьдрал, нөхцөл байдлын талаар хангалттай сайн мэддэггүй.
- 6 Улс төрд идэвхтэй оролцдог залуучуудыг “цүнх баригч” эсвэл хувийн эрх ашгийн төлөө эрх мэдэлд шунаж байна гэх мэтээр шүүмжилдэг олон нийтийн сөрөг хандлага байдаг.
- 7 Хөдөө орон нутагт залуу нэр дэвшигчдийг нийгмийн гарал үүсэл, төрсөн газар нутаг, хамаатан садан, ах дүүсээр нь ялгаварладаг.

Иймд, залуучуудын төлөөлөл улс төрийн шийдвэр гаргах түвшинд бага байгаад дараах хүчин зүйлс нөлөөлж байна:

- 1 Сонгуулийн томсгосон мажоритар тогтолцоо нь шинэ, залуу нэр дэвшигчдэд халтай байна.
- 2 Улс төрийн намын санхүүжилт залуучуудад ээлтэй биш байна.
- 3 Нийгмийн сөрөг хандлага залуучуудын улс төрийн оролцоонд саад болж байна

Залуу улс төрчдөд өгөх зөвлөгөө



Дээрх бэрхшээлийг залуу улс төрч Бадралын Мөнхдөл амжилттай даван туулж 2020 оны Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн ИТХ-ын сонгуульд ялалт байгуулжээ.

Тэрбээр 2020 оны УИХ-ын сонгуульд нэр дэвшсэн ч сонгуульд ялагдсан юм. Учир нь шинэ, залуу улс төрчийн хувьд сонгуулийн сурталчилгаанд шаардлагатай санхүүжилтийг богино хугацаанд бүрдүүлэх мөн өөрийгөө олон нийтэд таниулах зэрэг бэрхшээлтэй тулгарсан байна. Эдгээрийг даван туулахын тулд Мөнхдөл сошиал медиа дээр идэвхтэй үзэл бодлоо илэрхийлдэг байв. Мөн Сүхбаатарын талбайн урд барьсан усан оргилуурыг эсэргүүцэж ганц хүний эсэргүүцлийн жагсаалыг сар гаруй хугацаанд хийсэн нь олны анхаарлыг татаж чадсан юм. Түүнчлэн УИХ сонгуулийн сурталчилгааны 21 өдрийн 19-д нь тойргийнхоо иргэдтэй ганцаарчилсан уулзалт хийсэн байна.

УИХ-ын сонгуульд ялалт байгуулаагүй хэдий ч сонгуулийн туршлага хуримтуулж, сонгогчдод танигдаж чадсан нь ИТХ-ын сонгуульд амжилттай өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлсэн ажээ. Иймд, Мөнхдөл өөрийн туршлагаас хуваалцаж залуу улс төрчдөд дараах зөвлөгөөг өгч байна:

1

Залуучууд улс төрд оролцох хүсэлтэй бол зөв зорилгоор оролцоорой.

Нийтийн эрх ашгийн төлөө ажиллах хүсэл эрмэлзэлтэй байх, ийм ажил хийгээд таашаал авдаг бол маш сайн. Харин мөнгө хөрөнгө, эрх мэдэл, байр суурины төлөө улс төрд битгий оролцоорой.

2

Урт хугацааны зорилготой, алсын хараатай, тууштай улс төрд оролцох нь зөв.

Нэг удаа оролцоод шууд ялна гэж бодож хэрэггүй. Сонгуульд оролцоод ялагдсан ч гэсэн олон нийтэд танигдаад авлаа гэж бодоорой.

3

Тойргийнхоо иргэдийн амьдрал, тэдэнд тулгардаг асуудлуудыг сайн мэдэх хэрэгтэй.

Тэр тусмаа ИТХ-ын сонгуульд өрсөлдөж байгаа бол хаана хэнд ямар асуудал тулгамдаж байгааг тогтоон асуудалд шийдэл санал болгож байж сонгогчдын итгэлийг олж авна.

Залуучуудын улс төрийн идэвх оролцооны сайн жишээ



Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын ИТХ-ын төлөөлөгч Э.Саранчимэгийн түүх

Улаанбаатар хотын уугуул иргэн, сэтгүүлч мэргэжилтэй Э.Саранчимэг нь 2013 онд “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа” хэмээх 15500 өрхийг оролцуулсан томоохон судалгаанд ажиллахаар Сэлэнгэ аймагт очжээ. Энэхүү судалгаанд ажиллахдаа Сэлэнгэ аймгаар хөндлөн гулд 76 хоног явсан бөгөөд “хотын охин хөдөөгийн хөрсөн дээр бууж, иргэдийн амьдралын сайхан муухай хийгээд санаанд оромгүй зүйлсийг нүдээр үзэж чихээр сонссон” байна. Энэ ажил нь түүнд олон сургамж, ухаарал хайрлахын сацуу амьдралынх нь хань, алсын зорилго хоёрыг өгсөн ажээ.

Яагаад 2020 оны ИТХ-д нэр дэвших болсон бэ?

2014 онд унаган нутаг Улаанбаатараасаа 400 км алсад айлын бэр, хүний гэргий болж, сумын суугуул иргэн болох бусдын байтугай өөрийнхөө санаанд оромгүй амьдралын том алхам хийсэн билээ. Суманд амьдарч эхлээд, “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа”-гаар олж авсан олон асуудлыг шийдвэрлэмээр, нийгмийн харилцаанд орсон бүхий л харилцаа шүүмжлэлтэй санагдаж, сүүлдээ түүндээ бухимддаг болсон. Энэ бүхнээс гарах гарц шийдэл хайж яваад 2016 онд “Тогтвортой хөгжлийн боловсрол” төслийн сургагч багшийн сургалтад суух боломж олдсон. Ингээд л миний хэлэх гээд, хийх гээд байсан бүх зүйл чинь тогтвортой хөгжлийн зорилгуудад бүгд багтсан байгааг ойлгосон.

Нэг үе, улс төр бол муу муухай зүйл, залуус бидэнд огт хамаагүй, оролцох шаардлагагүй гэж боддог байлаа.

Харин 2018 онд ОУ-ын байгууллагуудын хамтарсан “Залуусын дуу хоолой” чуулганд оролцох үеэр нэгэн УИХ –ын гишүүний “Залуучууд улс төрөөс зугтаах хэрэггүй. Харин ч зоригтой оролцох хэрэгтэй. Тэгж байж улс төр эрүүлжиж, шлүү хүртээмжтэй, нээлттэй болно” гэж хэлсэн нь нэгийг бодогдуулж, сэдэл төрүүлсэн.

Товчхондоо бол, орон нутагтаа болж буй, болох гэж буй үнэн бодит мэдээллийг цаг алдалгүй авч, олон нийтэд хүртээмжтэй байлгахын тулд. Ярилаа гээд, ярилцлаа гээд юу ч өөрчлөгдөхгүй гэдэг залуучуудын бодол, хандлагыг өөрчилж, тэдэнд манлайлал хэвтээ гэдгийг нотлон харуулахын тулд, бүгд мэддэг хэр нь хэн нь ч ил гаргаж тавихгүй байгаа асуудлыг ил болгох гэж ИТХ-д нэр дэвшихээр болсон.

“

Орон нутагтаа болж буй, болох гэж буй үнэн бодит мэдээллийг цаг алдалгүй авч, олон нийтэд хүртээмжтэй байлгахын тулд. Ярилаа гээд, ярилцлаа гээд юу ч өөрчлөгдөхгүй гэдэг залуучуудын бодол, хандлагыг өөрчилж, тэдэнд манлайлал хэвтээ гэдгийг нотлон харуулахын тулд, бүгд мэддэг хэр нь хэн нь ч ил гаргаж тавихгүй байгаа асуудлыг ил болгох гэж ИТХ-д нэр дэвшихээр болсон.

Эмэгтэй нэр дэвшигчийн хувьд ямар саад бэрхшээл тулгарсан бэ? Хэрхэн даван туулсан?

Санхүүгийн, нутаг усны, нас хүйсийн, худал мэдээллийн, намын харьяаллын гээд олон саад бэрхшээл байсан. Юун түрүүнд сонгуульд нэр дэвших эрхээ авахын тулд аль нэгэн намын гишүүн байх, эсвэл бие даан нэр дэвших сонголт хийх хэрэгтэй байв. Орон нутагт МАН, АН гэсэн хоёр том нам л давамгайлдаг нь нууц биш. Бие даан нэр дэвшээд, сонгогдсон ч өөрийн оруулах санал, шийдвэрлүүлэх асуудал дээр шууд дэмжлэг авч чадахгүй тул аль нэг намыг түшиглэх хэрэгтэй болсон. “ҮЭ-ийн сонгууль ажилтнууд аливаа нэгэн намын харьяалалгүй байна” гэсэн үндсэн ажилтай минь зөрчилдөөд, нэр дэвшихээ болих тухай хүртэл бодов. Ингээд олон талаас нь эргэцүүлж, ойр дотнынхонтойгоо ярилцаад намын гишүүн болохгүйгээр, намын нэр дээрээс дэвших шийдэлд хүрсэн.

Харин сонгуулийн сурталчилгааны үед, өмнө болон одоо байгаа ИТХ-ын төлөөлөгч эмэгтэйчүүд, төрийн байгууллагуудад ажилладаг зарим нэг эмэгтэй удирдлагуудын арга барил, чадвараар миний чадварыг шууд дүгнэж үл итгэх байдал гаргах эсвэл хэн нэгэн

эмэгтэйн нэр цохон чи тэрнээс ямар ялгаатай, тэрнээс илүү юу хийж чадах юм гэж шууд харьцуулсан байдлаар тулгаж асуух нь олон байсан. Мөн эмэгтэй хүмүүс улс төрд орж, дарга болоод юу хийж чаддаг юм, эр нөхрийнхөө арыг даагаад, орон гэрээ олигтойхон аваад явах ёстой гэсэн хуучин цагийн хүйсийн хэвшмэл ойлголт нөлөө ихтэй байв. Дээрх үйлдэл, яриануудад эмэгтэйчүүдийн оролцоо илүүтэй байгаа нь хамгийн харамсалтай.

Энэ удаагийн сонгуульд нөхөртэйгөө хоёулаа нэр дэвшсэн тул нөхрийнхөө карьерыг унагана, нэр төрийг нь сэвтээнэ гэсэн найз нөхдийнх нь хандлага ч харагдаад амжсан.

Сонгогдсоны дараа ч намын гишүүн бус гэдэг шалтгаанаар хурлын тэргүүлэгч, аливаа нэг албан тушаалд томилох боломжгүй гэх асуудлын марафон үргэлжилсээр л байна. Өөрийнхөө хийсэн бүтээсэн, сурсан мэдсэн, ур чадвар, үйл хэргээрээ л энэ бүх асуудлыг шийдвэрлэх гарц хэмээн харсан. Учир нь миний үг, үйлдэл дараа дараагийн залуучууд, эмэгтэйчүүдийн өмнө улс төрд орох, оролцоогоо хангах хаалгыг том дэлгэх шалтгаан болох ёстой.

Бусад залуучуудад өгөх ямар сургамж байна?

Олон найзууд надаас, чи суманд юу хийгээд байгаа юм бэ, наана чинь ямар ирээдүй байгаа юм бэ гэж асуудаг. Харин ч хийх зүйл орон нутагт тэр дундаа суманд бүр их байна.

Саяхныг хүртэл залуусыг зүгээр л оролцоод өгөөч гэдэг байсан бол өнөөдөр утга учиртай оролцооч, зөв хандлагатай, хариуцлагатай байгаа гэхчлэн нийгмийн хүсэл хурдтай өөрчлөгдөж байна. Чамд ямар асуудал байна гэдэг асуултын араас үүнийг шийдэхийн тулд чи юу хийсэн бэ гэх асуулт үргэлж дагалдана.

Асуудлыг араас нь дагаж биш, өмнөөс нь угтаж шийддэг байцгаая. Хүсвэл, хамтарвал, хайвал боломж үргэлж байдаг.

Залуучууд тогтвортой хөгжлийг авчирна.

“

Уугуул уу суугуул уу, хэний хүүхэд, хэний эхнэр, хэний хамаатан, манай намд хэдэн жил зүтгэсэн бэ, эр үү эм үү, хөгшин үү залуу юу гэдгээр мөлждөг биш, хувь хүн нь хэн бэ, ямар чадвартай, юу хийж бүтээсэн бэ гэдгээр дэвшүүлдэг, сонгодог, итгэл үзүүлдэг сайхан цаг удахгүй ирнэ гэдэгт итгэлтэй байгаа.

Залуучуудын сонгуулийн ирц, улс төрийн идэвх оролцоонд эерэгээр нөлөөлж чадсан “Өглөө” төслийн туршлагаас

“Өглөө” төслийн зорилго нь юу бэ?

Манай улсын хүн амын дийлэнх хэсгийг залуучууд бүрдүүлдэг боловч тэдний сонгуулийн идэвх, улс төрийн оролцоо сүүлийн жилүүдэд тун хангалтгүй байсаар ирсэн. Залуучуудын сонгуулийн ирц муу байх нь тэдний дуу хоолой төрийн бодлогод тусгагдахгүй орхигдож, тэдэнд тулгамдсан ажилгүйдэл, боловсролын чанаргүйдэл зэрэг нийгэм, эдийн засгийн олон асуудлууд шийдэгдэхгүй үлдэх эрсдэл бий болгодог. Мөн залуучууд улс төрд идэвхгүй, оролцоогүй байх нь ардчиллын чанарт сөргөөр нөлөөлдөг. Иймд, 2020 оны УИХ болон ИТХ-ын сонгуульд залуучуудыг идэвхтэй оролцуулж саналыг нь өгүүлэх зорилгоор “Өглөө” төсөл 2020 оны 4 сард мэндэлсэн ажээ.

Уг төслийг Олон Улсын Бүгд Найрамдахчуудын Хүрээлэн, Азийн Сангийн дэмжлэгтэйгээр Зориг Сан болон UBP Media ХХК хамтран хэрэгжүүлсэн юм. Түүнчлэн энэхүү төсөл нь аливаа нэг нам, улс төрчөөс хараат бус, бүрэн бие даасан байж чадсан бөгөөд залуучуудын өөрсдийн оролцооны үр шимд бий болж, амжилттай хэрэгжсэн.

Төслийн хүрээнд залуучуудад хэрхэн нөлөөлж чадсан бэ?

Өглөө төслийг хэрэгжүүлэхдээ хамгийн тэргүүнд залуучуудыг оролцуулсан суурь судалгаа, фокус бүлгийн ярилцлага болон ардчилал-хакетон зэрэг ажлыг зохион байгуулжээ. Эдгээр судалгааны ажлуудын гол зорилго нь дараах асуултуудад үнэн бодит хариулт авах байв:

- 1 Залуучуудын сонгуулийн ирц яагаад муу байсаар ирсэн бэ?
- 2 Ямар хүчин зүйлс тэдний улс төрийн идэвх, оролцоонд эерэг болон сөргөөр нөлөөлж байна вэ?
- 3 Залуучууд ямар төрлийн контент сонирхож байна вэ? Тэдэнд хандсан нөлөөллийн мессежийг хэрхэн илүү үр дүнтэй болгож болох вэ?
- 4 Залуучууд социал болон уламжлалт медиаг хэрхэн хэрэглэж байгаа вэ?

Судалгааны дүнд залуучуудыг үндсэн хоёр бүлэгт хувааж тэдгээрт тус бүрд нь зориулсан нарын контентуудыг бэлдэж **СОЦИАЛ МЕДИАГААР ЦАЦСАН НЬ ЕРДӨӨ ХОЁР САРЫН ДОТОР ОЙРОЛЦООГООР ХАГАС СЯА ГАРУЙ ХҮНД ХҮРСЭН** байна.



Тухайлбал улс төр огт сонирхдоггүй, улс төрийн талаар сөрөг хандлагатай, сонгуульд оролцохыг чухалчилдаггүй залуучуудад хандаж #ДээлтэйСаналааӨглөө онлайн чалленжийг амжилттай зохион байгуулсан юм. Уг чалленжийн зорилго нь залуучуудын сонгуулийн талаарх сөрөг хандлагыг өөрчилж, сонгуульд саналаа өгөх нь “cool” юм шүү гэсэн мессежийг залуучуудад өгөх байсан ажээ.



Залуучуудын иргэний нийгмийн байгууллагын сайн туршлага

БОДЛОГОД ЗАЛУУСЫН ХЯНАЛТ ТББ

Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцад залуучуудын оролцоо, дуу хоолой үгүйлэгдэж байгааг өөрчлөх зорилгоор 2014 онд иргэний нийгмийн байгууллагад ажиллаж байсан, хүний эрхийн суурьтай залуучууд үзэл бодол, үнэт зүйлээрээ нэгдэж “Бодлогод залуусын хяналт” ТББ-г байгуулжээ.



Байгууллагын зорилго нь юу вэ?

- Тэд залуусын оролцоо гэдгийг ихэнхдээ өнгө будаг алагласан, олуулаа цугласан интертаймент байдлаар төсөөлдөг байсныг өөрчилж, бодлогын түвшин дэх залуусын оролцоог нэмэгдүүлэхээр ажиллаж байна.
- Залуус өөртөө хамааралтай асуудлаар шийдвэр гаргахад оролцох эрхтэй гэдгээ мэддэг хэдий ч хэрхэн, яаж оролцохоо мэддэггүй. Үүнд хариулт олж, үлгэр жишээ залуусын байгууллага болж, нийгмийн эерэг өөрчлөлтөд хувь нэмрээ оруулахыг зорьж байна.

Байгууллагын зорилгын дагуу ямар онцлох ажлуудыг хийсэн бэ?

- Улс төрийн намын тухай хуулийг боловсронгуй болгох чиглэлээр “УЛС ТӨР БА МӨНГӨ” хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.
- Сонгуулийн үеэр “ИРГЭНИЙ НИЙГМИЙН АЖИГЛАЛТ”-ын төслийг ННФ болон Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд ТББ-тай хамтран зохион байгуулдаг. Эдгээр төслийг хэрэгжүүлснээр сонгуулийн тухай хуулийг улам боловсронгуй болгоход тодорхой хувь нэмэр оруулж байгаа.
- 2019 онд “ҮНДСЭН ХУУЛИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТӨД ИРГЭДИЙН ОРОЛЦОО” аяныг иргэний нийгмийн залуусыг уриалан дөрвөн сарын хугацаанд хэрэгжүүлэхдээ ҮХНӨ-д Шүүхийн хараат бус байдлыг хангахтай холбоотой чухал заалтуудыг оруулахад хувь нэмэр оруулж, нөлөөлж чадсан. Тодорхой үр дүнд хүрч чадаж байгаа гол шалтгаан нь тухайн асуудлаа сайн судлахын зэрэгцээ тухайн салбарын судлаачид, эрдэмтэдтэй хамтран ажиллаж тэдний дэмжлэгийг авч, эргээд тэр мэдээллийг илүү хялбаршуулж, иргэд болон шийдвэр гаргагчдад хүргэж байгаад юм. Үүнээс иргэний нийгэм ба судлаачид хамтран ажиллах нь чухал гэдгийг харж болно.

Байгууллагыг бий болгож, тогтвортой үйл ажиллагаа явуулахад ямар бэрхшээлтэй тулгарсан бэ?

- 1 Байгууллагын нэрэндээ зорилгоо яаж шингээж харуулах вэ гэж их удаан бодож, олон удаа уулзацгаасан.
- 2 Байгууллагын дүрмээ боловсруулж, батлах гэж бүгдийг тэгээс эхэлсэн.
- 3 Байгууллагын онцлог нь үүсгэн байгуулагч, удирдах зөвлөл, ажлын албаны хүмүүсийн ихэнх нь хуульч, сэтгүүлч мэргэжилтэй. Тиймээс дүрмээ боловсруулж батлаад мөрдөөд явахад амар байдаг давуу талтай.
- 4 Шинээр байгуулагдсан байгууллагын хувьд ажлын байр, тоног төхөөрөмж, цалин гээд шийдэх зүйл олон байжээ. Түүнийг тууштай байдлаар даван туулсан бөгөөд цалинтай, цалингүй голдуу кофе шопоор оффислоод явсан үе их байжээ.

Бусад залуучуудын байгууллагуудад ямар зөвлөгөө өгөх вэ?



Байгууллага байгуулж ажиллана гэдэг бол маш том зорилгын төлөөх чухал үйл хэрэг. Тиймээс байгууллагынхаа үнэт зүйл, зорилго, зарчимд үргэлж хүндэтгэлтэй хандаж зарчмын бус алдаа огт гаргаж болохгүй.



Мэдээллийн зөрүү гаргахгүй байх тал дээр бүгд анхаарах нь чухал. Мэдээллийн зөрүүнээс үл ойлголцол, үл итгэлцэл үүсдэг.



ТББ-ын нэг чухал амин сүнс нь Удирдах зөвлөл, үүсгэн байгуулагчдын оролцоо, хувь нэмэр юм. Эдгээр хүмүүс нь зарим тохиолдолд байгууллагын гол хүний нөөц нь болох тохиолдол ч бий.

Залуучуудын иргэний нийгмийн байгууллагын сайн туршлага



Хаягдсан сонин ба эмэгтэйчүүдийн биеэ даасан ертөнц

Монголын Тэргэнцэртэй Иргэдийн Үндэсний Холбоо 2012 оноос хойш хаягдал цаасаар гэр ахуйн жижиг хэрэглэлийн бүтээгдэхүүн хийж 30 гаруй эмэгтэйн хөдөлмөр эрхлэлт, нийгэм – сэтгэл зүйн байдлыг сайжруулж хүчирхэгжихэд нь хувь нэмрээ оруулж байна. Бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь үнэтэй тоног төхөөрөмж, техник хэрэгсэл шаарддаггүй, айл бүрт байдаг хаягдал сонингийн цаас зэрэг материалыг түүхий эд болгон ашиглагдаараа давуу талтай юм.

Одоо тус хөтөлбөрийн Эко гифт хоршоо нь Имарт их дэлгүүрийн 3 салбарт өөрсдийн лангуугаа нээж бараа бүтээгдэхүүнээ худалдаж байна. Эко гифт хоршоо нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхээс гадна гэрээсээ гарч нийгэмд анх оролцож эхэлж байгаа эмэгтэйчүүдийн нийгэмшлийн гүүр болдог ажээ. Улмаар хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд уг хоршоонд гар урлал эрхэлж байгаад өөрийн сонирхол, мэргэжил цаашдын карьерыг тодорхойлж иргэний нийгмийн салбарт болон бизнесийн салбарт хувь нэмрээ оруулах алхмаа хийдэг байна.

Яагаад энэ хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн бэ?

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд өөрийн гэсэн орлого, бие даасан байдал, өөрийн бэрхшээлийн онцлогт тохирсон чадамжит ажил хөдөлмөр эрхэлж нийгмийн амьдралд оролцох хэрэгцээ зайлшгүй шаардлагатай байдаг. Түүнийг хангах зорилгоор “Хаягдсан Сонин Ба Эмэгтэйчүүдийн Биеэ Даасан Ертөнц” хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Хөтөлбөр хэрхэн бий болсон бэ?

- 1 Удаан хугацаанд гэртээ байгаа эмэгтэйчүүдийн нийгэм, сэтгэл зүйн байдал дээр үндэслэн Монголын Тэргэнцэртэй Иргэдийн Үндэсний Холбооны дэргэд албан бусаар чөлөөт цагаа өнгөрүүлэх бие биетэйгээ уулзах орон зайн нэг хэсэг болж явсаар энэ нь ХБЭ-ийн хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаа болж хувирчээ.
- 2 Эхлээд бүлэг хэлбэрээр өрнөж байгаад эмэгтэйчүүдийн өөрсдийн санаачилгаар хоршоо болж өргөжжээ.
- 3 Үйл ажиллагааны чиглэлээ илүү байгальд ээлтэй ногоон үйлдвэрлэл рүү чиглүүлсэн байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тулгарсан саад бэрхшээлийг хэрхэн даван туулсан бэ?

Эхний 2 жилд цаасан урлалын технологийг гүйцэд судлаагүй байсан ба түүнээс үүдэж нэгж бүтээгдэхүүний өртөг өндөр гарч ашиггүй ажилладаг байв. Технологи доо илүү суралцахын тулд энэ чиглэлийн багш нараас сургалт авч, тэр дундаас өөрсдийн гэсэн хамгийн бага өртөгтэй технологитой болсноор асуудлаа бага багаар шийдэж эхэлсэн байна.

Зааж сургасан хүмүүс нь ажлаасаа гарах үед хүн хүчгүй болох, технологи нь алдагдах бэрхшээлүүд тулгарч байв. Ажилтнуудаа цагаар ажиллуулах, эсвэл нэгж үнэлгээтэйгээр ажлыг хийлгүүлэх арга хэлбэр лүү шилжиж байж дээрх бэрхшээлийг даван туулж эхэлсэн аж. Ингэснээр эхний үед ашиг багатай байсан ч захиалагч нараа алдаагүй юм. Хоног хугацаа өнгөрөх тусам хэрэглэгч захиалагч нар нэмэгдэж байгаа ба түүний хирээр цагийн ажилтнуудын ажил, орлого нэмэгдэж байгаа юм. Үүний үр нөлөөгөөр сургаж бэлтгэсэн ажилтнуудаа буцаагаад ажиллуулж эхэлсэн байна.



Гарааны бизнес эхэлж байгаа залуучуудад ямар зөвлөгөө өгөх вэ?

Нэг багшаас сургалт аваад нэг ментортой болонгуутаа бүх технологийг болчихсон гэж бодох нь учир дутагдалтай. Тиймээс хийж буй бизнесийнхээ чиглэлээр олон хамтрагч, олон чиглүүлэгчтэй байж үргэлж шинийг эрэлхийлж суралцах нь чухал.

Эхний үед хүч хөдөлмөр гаргаж бэлдсэн ажилтнуудаа алдах эрсдэл байнга тулгарна. Тэр эрсдэлтэй үеийг даван туулах бэлтгэлтэй байх хэрэгтэй. Ажилтнуудаа итгэл үнэмшил, эрх мэдэл өгч, бараа нийлүүлэх, захиалга авах, түүхий эд материал авах ажилд нь өөрсдийг нь оролцуулах, ашиг орлогоо нээлттэй байлгах нь чухал. Ингэснээр тулгарч буй бэрхшээлийг багаараа даван туулах сэтгэл зүйтэй болно.



Ашиг багатай ажилласан сард их цалин авахгүй, ашигтай ажилласан үедээ цалин их авна гэдгийг ажилтнууд мэддэг байвал ойлголцлын зөрүү гардаггүй.

Бүтээгдэхүүний дизайн, сав баглаа боодол, хаяг шошго бол амжилтын эх үндэс. Хүмүүс хэрэглэж үзэхээсээ өмнө харж сонголтоо хийдэг. Мөн бүтээгдэхүүний танилцуулга, заавар сайн байх, тогтмол ажиллагаатай фэйсбүүктэй байх нь чухал.

Ашиг багатай байсан нь ч нэр хүнд бүхий том тогтмол захиалагч нартай болох, тэдэнтэй гэрээ хийж ажиллах нь дараагийн замыг нээж өгдөг. Жишээлбэл, бид Австралийн Элчин сайдын яамтай хамтарч төсөл хэрэгжүүлсэн нь маш үр дүнтэй байсан. Энэ төслийн хүрээнд бид анх удаа үзэсгэлэнгээ зохион байгуулж анхны байнгын захиалагч нартай болж байв.



YVote app танилцуулга:

Иргэний боловсролын төвөөс "Бүгд залуусын төлөө, залуус бүгдийн төлөө" төслийн хүрээнд залуу сонгогчдын боловсролд зориулан бүтээсэн **YVote** аппликэйшнийг нээмэгц үндсэн зургаан цэс харагдана. +18, Намайг сонгооч, Яг чам шиг, Чухал юмнууд айсуй, Дархлаатай мэдээ, Хэдиймбэ.





YVote Аппликэйшний зорилго:

Залуучуудын сонгогчийн боловсролыг нэмэгдүүлж, орон нутгийн болон үндэсний төвшинд өөрийн эрх ашигт нөлөөлөх аливаа асуудлаар шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, хянаж үнэлэхэд оролцох эрхээ бодит үйлдэл хийхэд туслахад оршино.


Залуучуудын оролцоог дэмжих аппликэйшний агуулга:

Аппликэйшний үндсэн агуулга нь төрийн засаглалд залуучуудын оролцох эрх, орон нутгийн болон үндэсний төвшинд залуучууд өөрийн эрх ашигт нөлөөлөх аливаа асуудлаар шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, хянаж үнэлэхэд оролцох боломж, арга хэлбэр, төрөл, ач холбогдол, оролцооны шатлал, утга учиртай оролцооны зарчмууд, сонгогчийн болон улс төрийн боловсролын мэдээллээс бүрдэнэ.

YVote аппликэйшний гол давуу тал нь өмнө нь нэг ч удаа санал өгч байгаагүй хүн ч (15-34 насныханд зориулсан) санаа зовох зүйлгүйгээр сонгууль, намуудын тогтолцоо, улс төрийн үзэл баримтлалын талаар суурь ойлголтуудыг уншиж мэдэх, цаашлаад ирэх сонгуулийн дэлгэрэнгүй мэдээллийг хялбараар хүртэх, ямар ямар төвшинд, хэрхэн оролцож болохыг ойлгох юм.



YVote татаж авах:





Бүгд залуусын төлөө, Залуус Бүгдийн төлөө

Хэрэгжих хугацаа:

2020.1.1 - 2023.12.31

Төслийн зорилго:

Залуучуудын хөгжил, оролцооны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ын чадавхыг бэхжүүлэх, хамтын ажиллагааны сүлжээ үүсгэн судалгаа, нөлөөлөл хийх замаар Монгол улсын засаглал, хөгжлийн явцад хувь нэмэр оруулах иргэний нийгмийг бэхжүүлнэ.

Төслийн зорилт:

Залуучуудад илүү санаачилга, оролцоотой байж, нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулах шаардлагатай мэдлэг, ур чадвар, эрх мэдлийг нэмэгдүүлэх зорилгоор Төрийн бус байгууллагуудын чадавхыг нэмэгдүүлнэ.



Хамрах хүрээ:



САНХҮҮЖҮҮЛЭГЧ:



Funded by the
European Union



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:

